



Г ХӨВСГӨЛ УСАН ЗАМ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛД Т

СҮЛД-АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Бага тойруу 8 дугаар хороо, 11-р  
хороолол GB-центр #502 тоот  
Утас:(976) 98220935, 99114056  
E-mail: [info@suld-audit.mn](mailto:info@suld-audit.mn)

2022.03.09

№ 22/06

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Хязгаарлалттай дүгнэлт

Бид "Хөвсгөл Усан Зам" Хувьцаат Компанийн (цаашид "Компани" гэх) 2021 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

### Аудиторын дүгнэлт

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай Дүгнэлтийн Үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол, "Хөвсгөл Усан Зам" ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

### Хязгаарлалттай Дүгнэлтийн Үндэслэл

1. Тухайн байгууллагын эрхэлж буй аялал жуулчлалын үйл ажиллагаа багассантай холбоотой тайлант жил болон өмнөх жилүүдэд алдагдалтай ажиллаж үйл ажиллагаа нь доголдсон мөн эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх зорилгоор их хэмжээний зээл авсан нь тухайн байгууллагын цаашдын үйл ажиллагаанд санхүүгийн хүндрэл учруулах тодорхой бус байдлыг үүсгэж байна.

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан болно.

Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан аудитын хязгаарлалтай дүгнэлтийн үндэслэл гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

#### *Аудитын гол асуудал*

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тусгасан асуудлаас гадна дор дурдсан бусад асуудлыг бид тайландаа мэдээлэхүйц аудитын гол асуудал хэмээн тодорхойлоод байна.

#### *Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага*

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хариуцлага хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага байгууллагын үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

#### *Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага*

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

ХҮНДЭТГЭСЭН,  
Сүлд-Аудит ХК  
Ерөнхий Захирал, МНБ

*Ч.Гүндбаяр*  
Ч.Гүндбаяр  
00322  
2867556

